



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, төвийн даргын 2017 оны А/06 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 13.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн дунд хугацааны /стратегий/ төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	Н.Нэргүй	Ахлах арга зүйч
Нарийн бичгийн дарга	Б.Халиунаа	Нийгмийн ажилтан
Гишүүд	Б.Энхдөлгөр Б.Нандинцэцэг Э.Пүрэвсүрэн П.Ариунбилэг Д.Ганзаяа	Нягтлан бодогч Ахлах нийгмийн ажилтан Нийгмийн ажилтан Сэтгэл зүйч Архив, бичиг хэргийн ажилтан

2. Төвийн стратегийн төлөвлөгөө боловсруулах ажлыг удирдлагаар ханган ажиллаж, гүйцэтгэлийг 06 дугаар сарын 25-ны дотор даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Н.Нэргүй/-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр ханган, төвийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлыг гардан зохион байгуулж ажиллахыг Б.Нандинцэцэг, Б.Халиунаа нарт даалгасугай.

ДАРГА  Т.МЭНЭНДУЛАМ



318060068

